



МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ  
ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

2019 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 10.

Улаанбаатар хот

“Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай”  
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”  
хуулийн төслийн тухай

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг (цаашид хуулийн төсөл гэнэ) боловсруулж, холбогдох төрийн байгууллага болон олон нийтээс санал авахаар хэлэлцүүлэг явуулж байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шинжээчид, холбогдох референтүүд хуулийн төсөлтэй танилцаад дараахь санал, дүгнэлтийг хүргүүлж байна.

**Нэг. Хуулийн төслийн үзэл баримтлалын тухай**

1.Хуулийн төслийн үзэл баримтлалд “Дэлхийн эдийн засгийн форумас гаргадаг “Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлт”-д дэлхийн 140 орноос Монгол Улс нийлбэр дүнгээр 93 дугаарт, “олон улсын нээлттэй байдал” буюу жуулчны виз олгох нөхцөлийн үзүүлэлтээр 128-д, “газрын боомтын дэд бүтцийн хөгжил” үзүүлэлтээр 126-д, “жуулчны үйлчилгээний дэд бүтэц” үзүүлэлтээр 105-д, “агаарын тээврийн дэд бүтэц” үзүүлэлтээр 97 дугаар тус тус эрэмблэгдсэн байна. Иймд виз олгохтой холбоотой нөхцөлийг хөнгөвчлөх, шийдвэрлэх замаар Монгол Улс олон улс болон бүс нутагтаа өрсөлдөх чадвараа дээшлүүлж, аялал жуулчлалын хөгжлийг эрчимжүүлэх шаардлага урган гарч байна” гэжээ.

Хуулийн төслийн танилцуулга болон үзэл баримтлалд энэхүү тоон үзүүлэлтийг “...Монгол Улсын виз мэдүүлэхэд маш хүндрэлтэй” гэсэн үндэслэл болгоод, “...виз олгохтой холбоотой нөхцөлийг хөнгөвчлөх, шийдвэрлэх замаар Монгол улс олон улс болон бүс нутагтаа өрсөлдөх чадвараа дээшлүүлж, аялал жуулчлалын хөгжлийг эрчимжүүлэх шаардлага урган гарч байна” гэхчлэн хэт өрөөсгөлөөр хэсэгчлэн салгаж авсан үзүүлэлтийг практик шаардлага болгожээ.

Гэтэл аливаа улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын үндэс нь хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдал байдаг. Иймд дэлхийн бүх улс орон өөрийн нутаг дэвсгэртээ хил болон гаалиар нэвтрүүлэх хяналт, шалгалтыг өөрийн улсын эрх ашиг, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс маш хатуу, нарийн тогтоодог журамтай.

Монгол Улс, Дэлхийн эдийн засгийн форумын “Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлт”-ээр ийнхүү доогуур үнэлгээ авсан нь үнэн хэрэгтээ дан ганц “олон улсын нээлттэй байдал” буюу жуулчны виз олгох нөхцөлийн үзүүлэлтээс бус харин “хангах орчин нөхцөл”, “аялал жуулчлалын бодлого ба хангах нөхцөл”, “дэд бүтэц”, “байгаль, соёлын нөөц”, “байгаль орчны тогтвортой байдал” зэрэг бусад үзүүлэлтээр бага үнэлгээ авсантай шууд холбоотой байна. “2019 оны аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлтийн тайлан”-гаас харахад Монгол Улс “Хангах орчин нөхцөл”-өөр 66-д, “Аялал жуулчлалын бодлого ба хангах нөхцөл”-өөр 113, “Дэд бүтэц”-ээр 111, “Байгаль, соёлын нөөц”-р 62-т орж байна. Үүнд: Монгол Улс “Аялал жуулчлалын бодлого ба хангах нөхцөл” үзүүлэлтээр 113-т орж буй нь дан ганц “олон улсад нээлттэй байдал” үзүүлэлтээр 128-д орж байгаагаас болж буй бус харин ч “байгаль орчны тогтвортой байдал” үзүүлэлтээр 131-д орж байгаас, мөн “Дэд бүтэц”-ийн үзүүлэлтээр 111-д орж байгаагаас тус тус болж байна гэж үзэхээр байна. Тэгэхээр “Монгол Улс олон улс болон бүс нутагтаа өрсөлдөх чадвараа дээшлүүлж, аялал жуулчлалын хөгжлийг эрчимжүүлэх”-ийн тулд зөвхөн “олон улсад нээлттэй байдал” буюу виз олгохтой холбоотой нөхцөлийг хөнгөвчлөхөөс илүүтэй эхлээд “байгаль орчны тогтвортой байдал” болон “дэд бүтэц” үзүүлэлтүүдээ сайжруулах хэрэгтэй байна. Жишээ нь, “олон улсад нээлттэй байдал” үзүүлэлтээр Монгол Улсаас доор буюу 137-д орж буй Саудын Араб улс нь аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр Ойрх Дорнод, Хойд Африкийн улс орнуудын дотроо тэргүүнд, дэлхийн 140 орноос 69-д жагсаж байна.

Гэтэл аялал жуулчлал, ялангуяа түүний нэг чухал суурь болсон соёлын өвийн газруудын сэргээн засварлалт, хадгалалт хамгаалалт, үйлчилгээг төдийлөн сайн анхаардаггүй, дэд бүтэц сул манайх шиг улс зөвхөн визийн нөхцөлийг хөнгөвчлөх арга замаар асуудлыг шийдэх гарц биш гэж үзэж байна.

Иймд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд шаардлагатай агаарын, газрын, аялал жуулчлалын үйлчилгээний дэд бүтцийг байгуулах, төрөөс аялал жуулчлалын салбарыг дэмжих бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх, энэ төрлийн бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, дэмжих, түүх дурсгалын газруудаа сэргээн засварлах, үнэ тарифийн ялгааг арилгах, эрүүл, цэвэр, аюулгүй орчныг бүрдүүлж чадах аваас виз олгох нөхцөлийг хөнгөвчлөх тухай асуудал яандаа урган гарч ирдэг нь аялал жуулчлал өндөр хөгжсөн улс орнуудын туршлагаас бэлхэнээ харагдаж байдаг юм.

Түүнчлэн хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад Монгол Улсын виз мэдүүлэхэд ямар хүндрэл учирч байгаа, түүнд ямар хүчин зүйл, шалтгаан нөхцөл байгааг дурдаагүй, тоо баримт, жишээгээр нотлоогүй байна.

2. Хуулийн төслийн үзэл баримтлалд “гадаад улс орнууд виз мэдүүлэх үйл ажиллагаатай холбоотой визийн материалын бүрдлийг хянах, зөвлөгөө, мэдээлэл өгөх зэрэг техникийн чанартай ажиллагааг визийн төв буюу хувийн хэвшлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх чиг хандлагыг баримталж байгаа бөгөөд манай улсын хувьд ч мөн Монгол Улсын визийг олон тоогоор мэдүүлдэг улс орнуудад визийн төв ажиллуулах шаардлагатай...” байна гэжээ.

Хэдийгээр визийн мэдүүлгийн төв нь виз олгох шийдвэрийг гаргахгүй, техникийн үйлчилгээ үзүүлэх зорилготой ч жуулчин болон ажиллах хүч олноор хүлээн авдаг гадаадын бусад улс оронтой харьцуулбал манай улсад зорчих гадаад иргэдэд үзүүлэх визийн үйлчилгээний ачаалал төдийлэн их биш юм. Гадаад орны туршлагаас үзэхэд Арабын Нэгдсэн Эмират Улсад төвтэй дэлхийн хамгийн том аутсорсинг компани болох “VFS Global” компани нь виз мэдүүлэгчдийн мэдээллийг алдсан, түргэвчилсэн үйлчилгээг санал болгон бизнесийн ашиг хийсэн, виз мэдүүлэгчдээс хэт өндөр үйлчилгээний хөлс авсан зэрэг олон зөрчилтэй үйл ажиллагаа явуулсныг бид анхаарах шаардлагатай.

Иймд Монгол Улсын визийн мэдүүлгийн төв байгуулах зайлшгүй шаардлага бий эсэхийг дахин нягталж үзэх нь зүйтэй. Түүнчлэн Визийн төвийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай нөөцийн бэлэн байдал бүрэн хангагдсан эсэхийг тогтоосон судалгаа, учирч болох эрсдлийг даван туулах эрсдлийн үнэлгээний судалгаа зэргийг огт хийгээгүй байна.

Мөн “...гадаад улс оронд Монгол орныг сурталчлах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг ойртуулах, хууль бус дундын зуучлалыг багасгах, дипломат төлөөлөгчийн газруудын ачааллыг бууруулах...” ач холбогдолтой хэмээн үндэслэлээ тайлбарлажээ. Гэтэл гадаад улс орнуудад суугаа Монголын дипломат төлөөлөгчийн газрууд нь визийн асуудлаар хир их ачаалалтай байдаг талаар тухайлан судалгаа хийх шаардлагатай юм. Энэчлэн “хууль бус дундын зуучлал” үнэхээр байгаа эсэх, тэр нь хэр их түгээмэл болох, ямар оронд энэ үзэгдэл гарч буй талаар, тухайн оронд сууж буй дипломат төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа үнэхээр ачааллаа дийлэхгүй байгаа зэргийг нарийвчлан судалж, учир шалтгааныг нь үнэн зөв бодитой тогтоохгүйгээр хуулийн төслийн үзэл баримтлал, практик хэрэгцээ шаардлагад оруулах нь зохисгүй байна.

3. Хуулийн төслийн үзэл баримтлалд визийг боомт дээр болон цахимаар олгох практик шаардлагатай байна гэжээ.

НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас гаргасан “Visa opens report 2018 (Визийн нээлттэй байдлын тайлан-2018)” тайланд дэлхийн нийт улсын 53% нь уламжлалт визийн дэглэмтэй, 16% нь хил дээр виз олгодог, 21% нь визгүй, 10% нь цахим виз олгож байна гэжээ. Энэхүү тайлангаас харахад, Хойд Америк, Европ, Зүүн хойд Ази, Африкийн ихэнх улсын визийн нээлттэй байдал нь бага буюу хаалттай байна. Мөн 2 улсын харилцан зөвшөөрснөөр хил дээр олгодог виз болон цахим визийн хувьд 2012 онд 3%, 2013 онд 2%, удаах жилүүдэд 3%, 2018 онд дөнгөж 4-хөн % байгаа нь интернет, техник технологийн хөгжлийг дагаад визийн цахим үйлчилгээ хөгжих бүрэн боломжтой ч өөрийн биеэр биш цахимаар мэдүүлэх нь эрсдэл ихтэй гэдгийг нотолж байна.

Энд Монгол Улс олон улсын жишиг 53%-тай хамт байх уу эсвэл 26%-руу (хил дээр виз олгодог 16%, цахим виз олгодог 10%) шилжих үү гэсэн асуулт урган гарч байна.

Ийнхүү дэлхийн дахинд даяаршлалыг даган гарч байгаа терроризм, цагаачлал зэрэг сөрөг үр дагавраас болж визийн нөхцөл, виз олгох журмыг улам чангатган, уламжлалт визийн дэглэмийг баримталсаар байхад манай улс мэдээллийн аюулгүй

байдлаа бүрэн хангаж чадаагүй байгаа өнөөгийн нөхцөлд виз олгох нөхцөлөө хөнгөвчлөх нь өндөр эрсдэлтэй юм. Эдгээрээс харахад, хуулийн төслийн үзэл баримтлал болон танилцуулга дахь “Монгол Улсын визийг олон улсын жишигт нийцүүлэх” гэсэн үндэслэл тогтоогдохгүй байна.

4. Хуулийн төслийн үзэл баримтлалд “Монгол Улсын визийн хүчинтэй байх хугацаа нь бусад улс оронтой харьцуулахад харьцангуй богино байгаа бөгөөд энэ нь олон орноор дамжин аялал хийж байгаа болон аялалаа эртнээс төлөвлөдөг гадаад иргэдийн хувьд хүндрэл үүсгэдэг тул үүнийг өөрчилж, олон улсын жишгийн дагуу визийн хүчинтэй байх хугацааг одоо байгаагаас уртасгах нь гадаадын иргэдэд учрах хүндрэлийг бууруулах, тоог нэмэгдүүлэх давуу талтай юм” гэжээ.

Энд мөн л аялалаа эртнээс төлөвлөдөг гадаадын иргэдэд чухам ямар хүндрэл гардаг (аялалаа төлөвлөхөд хүндрэлтэй байдаг, эсвэл төлөвлөсөн ч бодит байдалд хүндрэл гардаг, эсвэл огт төлөвлөөгүй учраас хүндрэл гардаг гэхчлэн) талаарх санал гомдол болон судалгаа байхгүй байна.

Дээрх өөрчлөлтийг мөн л аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаад иргэдэд үүсч байгаа хүндрэлийг арилгах зорилготой гэж тайлбарлаж байгаа ч ОХУ, БНСУ, АНУ зэрэг улсад визийн хүчинтэй байх хугацаа 90 хоног, БНХАУ-д 30 хоног байгааг судлан үзэхийн зэрэгцээ визийн хугацааг ийнхүү нэмэгдүүлснээр цаашид дотоодын иргэдэд, ялангуяа үндэсний аюулгүй байдалд үүсч болох үр дагаварыг тооцож, түүнийг зохицуулах эрх зүйн зохицуулалтыг орхигдуулсан байна.

Олон улсын харилцаанд улс орнууд харилцан адил байх зарчим баримталдаг. Тиймээс визийн хугацааг гадаад орнууд манай улсын иргэдэд виз олгож байгаа хугацаатай нь адил хугацаагаар олгох нь олон улсын жишиг, дипломат харилцаанд ч нийцэх юм.

5. Хуулийн төслийн үзэл баримтлалд хууль ёсны хамтран амьдрагчийн тухай ойлголтыг хуульд тусгах замаар гадаадын иргэний эрх зүйн байдалтай холбоотой хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгоно гэжээ.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 28.1-д заасан “гадаадын иргэний эхнэр, нөхөр, төрүүлсэн эцэг, эх, хүүхэд” гэж тухайн хүнтэй эрх зүйн хувьд шууд хамаарал бүхий этгээдийг заасан. Гэтэл хуулийн төсөлд “хамаарал бүхий этгээд” гэдэгт “хамтран амьдрагч” гэсэн нэр томъёог нэмж оруулсан байна.

Гадаад улс оронд “хамтран амьдрагч” гэсэн ойлголтыг өргөнөөр хэрэглэдэг. Монгол Улсын холбогдох хуулиудад, тухайлбал, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэрч хохирогчийг хамгаалах тухай, Нийтийн албанд болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Татварын ерөнхий хууль, Цагдаагийн албаны тухай, Эрүүгийн хуульд “хамтран амьдрагч” гэдэг нэр томъёог мөн хэрэглэдэг. Гэхдээ “хамтран амьдрагч” нь эрх зүйн аливаа харилцаанд оролцохдоо тухайн хүнтэй хамтран амьдардаг гэдгээ баримтаар болон бусад байдлаар заавал нотолдог.

Иймд гадаад улсын иргэнийг дагаж Монгол Улсад ирэх “хамтран амьдрагч”-ийг хэн, хэрхэн тодорхойлох, нотлох нь ойлгомжгүй, тодорхой бус, эсхүл аль нэгэн гадаадын иргэн манай улсад ирсэн хойноо “хамтран амьдрагч”-тай болсоноор хэзээ ч эргэж гарахааргүй болж мэдэх нөхцөл бүрдэх боломжтой байгаа тул хуулийн төслөөс уг нэр томъёог хасах нь зүйтэй болно. Жишээлхэд, өнөөдрийн байдлаар Монгол Улсад оршин сууж буй Вьетнам улсын иргэд /Вьетнам авто засварын газар ажиллуулдаг/, Пакистан, Бангладеш улсын иргэд /авто машины худалдаа эрхэлдэг/ нь Монгол Улсад визийн нөхцөл, төлбөр зэргээс хөнгөрөх, удаан хугацаагаар оршин суух зорилгоор “хэлбэр төдий гэрлэлт” ашиглан гэр бүлийн буюу GB ангилал /нөхөр нь гадаад улсын иргэн/-аар оршин сууж байна. Хамтран амьдрагч гэсэн нь эзэн бие тодорхойгүй, эрх зүйн үр дагаварыг тодорхойлох боломжгүй нөхцлийг бий болгосон /энэ нэршилд тоон утгыг хэрхэн тодорхойлох зохицуулалт байхгүй/ байна.

6. Монгол улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх, халдашгүй байдал, тэдгээрийн баталгааг тогтоох, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг Монгол улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиар зохицуулж буй.

Гадаадын иргэнд орогнох эрх олгох эрх зүйн зохицуулалтыг Монгол улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудалд хөндлөнгөөс оролцсон хэрэг болжээ.

Тэгээд ч энэ харилцааг журамлан орогнол олгох үйл ажиллагааг эхлүүлэх цаг нь одоо мөн үү? гэдгийг үндэсний аюулгүй байдал, Монгол Улсын язгуур эрх ашгийг хамгаалах үүднээс маш нарийн судалгаа хийх шаардлагатай.

**Хоёр. “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн тухай санал**

1. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1/5 дугаар зүйлийн 5.1.14 дэх заалтын хамаарал бүхий этгээд гэсэн нэр томъёо, нэр томъёог дагасан хуулийн заалт, эшлэлд **хамтран амьдрагч** гэсэн нэршлийг оруулж байгаа нь эзэн бие тодорхойгүй, эрх зүйн үр дагаварыг тодорхойлох боломжгүй нөхцлийг бий болгосон /энэ нэршилд тоон утгыг хэрхэн тодорхойлох зохицуулалт байхгүй/ дордуулсан заалт байна.

2. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2/9 дүгээр зүйлийн 9.8 дах хэсэгт Үндэсний аюулгүй байдлын үндсэн зарчмыг агуулгаар нь тодорхойлж байгаа нь зөв хэдий ч хуулийн зүйлчлэлд тусгахдаа Төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх, аж ахуйн нэгж, иргэний үүрэг гэсэн бүлэгт тусгаж гажуудуулсан байна. Түүнчлэн Үндэсний аюулгүй байдлын үндсэн зарчмыг хуульчилсан ч хуулийн төслийн бичвэрт томъёолохдоо гадаадын иргэнд давуу эрх олгосон, аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааг хүчгүйдүүлсэн байна.

3. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3/11 дүгээр зүйлийн 11.9 дэх хэсэгт “...Гадаадын иргэн нь виз авах хүсэлтээ Монгол улсын дипломат төлөөлөгчийн газар, эсхүл Визийн төвд гаргаж болно.” гэж заасан нь хоёрдмол утгатай ямар тохиолдолд аль газраар үйлчлүүлэх нь тодорхойгүй. Түүнчлэн Визийн төвийг ажиллуулах нөөцийн бэлэн

байдал хангагдсан эсэх, ямар субъект эрхлэн явуулах гэх мэт асуудал тодорхойгүй байна.

4. Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 9.1 дэх хэсгийн “орогнох эрх олгоно.” гэсний дараа “Монгол улсад орогнох эрх олгох, үндэслэл, журмыг Монгол улсын Ерөнхийлөгч батална” гэсэн нь Монгол улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх, халдашгүй байдал, тэдгээрийн баталгааг тогтоох, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг Монгол улсын Ерөнхийлөгчийн тухай хуулиар зохицуулахаар хуульчилсантай нийцэхгүй байна.

Тэгээд ч хуулийн төслийн үзэл баримтлалд огт тусгагдаагүй Монгол Улсад орогнох эрх олгох асуудлыг журамлахаар хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан байна.

5. Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 37.2 дах хэсгийн “байгууллагын дарга гаргана.” гэсний дараа “Албадан гаргагдсан гадаадын иргэн нь албадан гаргагдсан үндэслэлээс хамааран 1-10 жилийн хугацаанд Монгол Улсад орох эрхгүй байна.” гэж нэмсэн нь хуулийн зүйл, заалт, хэсэг нь тус бүрдээ утга илэрхийлж төгсөх гэсэн зарчмыг алдагдуулсан. Хэт харьцангуй интервал заасан, хугацааны заалтыг үзэмжээрээ хэрэглэх боломж олгож байна.

6. Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3/11 дүгээр зүйлийн 11.3 дах хэсэгт “Визийг хэвлэмэл хуудас болон цахимаар олгож болно.” гэсэн нь хуулийн нэр томъёо, тодорхойлолтод тусгагдаагүй нэршлийг хуулийн төслийн бичвэрт оруулсан, түүнчлэн нэмэлт өөрчлөлтийн төсөлд ч нэр томъёог шинээр тусгаагүй байна.

7. Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 5/18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт Монгол Улсын хилээр нэвтрэх визийн хүчинтэй байх хугацаа 90 хүртэлх хоног байгааг 180 хоног болгон өөрчлөхөөр тусгажээ. Хэдийгээр олон улсын иргэний агаарын тээврийн Чикагогийн конвенцийн 9 дүгээр хавсралтын 3.26-д гишүүн улс орнуудыг визийн хүчинтэй хугацааг уртасгахыг зөвлөмж болгодог ч улс орнууд тус тусын нийгэм, эдийн засгийн байдал, газар зүйн онцлог зэрэг нөхцөл байдлаас шалтгаалж визийн хүчинтэй хугацааг нэмэгдүүлдэггүй. Тиймээс одоо олгож байгаа 90 хоног нь хангалттай гэж үзэж түүнийг сунгахыг дэмжихгүй байна.

### **Гурав. Дүгнэлт**

Хуулийн төслийг боловсруулахдаа Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.1.2.3-т “Гадны дүрвэгсэд олноор хил даван орж ирэх, гэнэтийн хяналтгүй нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх бэлэн байдлын тогтолцоог бүрдүүлж, эрх зүй, улс төр, дипломатын цогц арга хэмжээ авна” гэж, 3.1.3.3-т “...Хоёрдмол харьяалал үүсч, төрөөс иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах баталгаа алдагдахаас сэргийлэх” гэж, 3.1.3.5-д “Гадаад иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшинг хадгалж, бүртгэл мэдээллийн тогтолцоо, эрх зүйн орчин, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгоно” гэж тус тус заасныг сайтар харгалзаж үзээгүй байна.

1. Монгол Улс нь цөөн хүн амтай, дэлхийн хамгийн их хүн амтай улстай хиллэлдэг, хөрш орнуудын уламжлалт харилцаа, газар зүйн байрлал зэрэг онцлогийг харгалзан гадаадын иргэдийн хилээр нэвтрэх, зорчих асуудалд туйлын болгоомжтой хандахаас

гадна виз олгох журам нь “тогтоосон хяналтанд”, улсын хил- улсын үүд хаалга нь “чанга” байх бодлогыг баримтлах нь зүйтэй.

2. Аялал жуулчлал, дэд бүтэц хөгжөөгүй, гадаад иргэдийн шилжилт хөдөлгөөнийг хянах хүн хүч, техникийн боломж бүрдээгүй байгаа үед визийг хөнгөвчилснөөр олон улсын гэхээс илүү нэг улсын жуулчдын урсгал ихсэх, тэдгээрийн шилжилт хөдөлгөөнийг бүрэн хянаж чадах эсэх нь эргэлзээтэй гэдэг нь саяхан манай улсад гарсан 800 хятад иргэний үйл, үйлдэл харуулж байна. Иймд аялал жуулчлалыг хөгжүүлэх, олон улсын жишгийн дагуу боловсронгуй болгох гэдэг үндэслэлээр визийн нөхцөлийг хөнгөвчлөх асуудал нь цаг үеэ олоогүй, төрийн бусад салбарын бодлоготой уялдаагүй байна.

3. Хуулийн төслийн үзэл баримтлалд заасан Монгол Улсын виз олголт нь хүндрэлтэй байгаа гэх шалтгааныг тодорхойлсон үндэслэл бүхий судалгаагүй байна. Мөн гадаадын иргэдийн аялалаа төлөвлөх эрх ашгийг ихэд анхаарсан атлаа Монгол Улсын язгуур эрх ашигт хэрхэн нийцэж байгааг тооцоолж, хамгаалалт хийгээгүй байна.

4. Нийгэм, эдийн засгийн өндөр хөгжилтэй, аюулгүй байдал нь сайн хангагдсан, аялал жуулчлал өндөр хөгжсөн, хүн ам ихтэй гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөнд ил, далд хяналтаа сайн тавьдаг хөгжингүй орнуудын практик жишгийг хуулбарлах нь манай улсын хувьд тохиромжгүй юм. Мөн гадаадын иргэдэд үзүүлэх үйлчилгээг хөнгөвчлөх гэх зорилгоос илүүтэйгээр өөрийн улсын язгуур ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих нь төрийн үүрэг тул улсын хилээр нэвтэрч буй гадаадын иргэдийн бүртгэл, хөдөлгөөний хяналтыг улам боловсронгуй болгох шаардлагатай.

Гэтэл уг хуулийн төсөлд энэ асуудлыг зохицуулсан дорвитой сайжруулсан тодорхой зүйл заалт хангалттай тусгагдаагүй байна.

5. Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгад хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг оновчтой зөв томъёолоогүй, тэдгээрийг нотолсон судалгааны тоо баримт, жишээ баримт туйлын дутмаг хангалтгүй байна.

Иймд энэхүү хуулийн төсөл нь визийн нөхцөлийг хөнгөвчлөх явдлыг аялал жуулчлалыг эрчимжүүлэх арга зам гэж өрөөсгөл үзсэн; Азийн хүн ам ихтэй болон хөгжингүй орнуудын жишээг өөрийн улсын хөгжил, хүн амын тоо, эдийн засгийн чадавхи, нийгмийн төлөвшилтийг харгалзалгүйгээр нэвтрүүлэн хэрэглэхийг оролдсон; Гадаадын иргэнд орогнол олгох харилцааг хуульчилан эхлүүлж буй нь цаашдаа Монгол улс “Гадаадын цагаачдыг хүлээн авах тухай хууль”-тай болох хөрс суурийг бэлтгэсэн хэрэг болжээ.

Монгол улс Дүрвэгсдийн статусын тухай НҮБ-ын 1951 оны конвенци болон түүний 1967 оны Протоколд элсэж ороогүй болохын учир шалтгааныг хуулийн төсөл санаачилагчид сайтар судалж танин мэдвэл зохино.


Хуулийн төсөл боловсруулах ажлыг зөвхөн энэ асуудлыг хариуцсан яам, агентлаг дагнаж, удирдан боловсруулсан нь байгууллагын амбицад хэт автаж виз олголтын үйл ажиллагаанд оршиж буй эрсдэл, сул талыг бодитой харж чадаагүй, үүсээд буй бодит

нөхцөл байдлыг зөв тодорхойлж, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагыг оновчтой томъёолоогүй байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь эрх зүйн харилцаанаас үүдэн гарах сөрөг үр дагаварыг тооцоолоогүй, Монгол улсын хүн амын жижиг бүтцэд тулгуурласан гадаадын иргэний эрх зүйн харилцаанд оролцох алхамыг судлаагүй, тооцоо дүгнэлтгүйгээр боловсруулагдсан байх тул энэхүү хуулийн төслийг хэлэлцэхгүй байх нь зүйтэй гэж үзэж байна.


ДҮГНЭЛТ ГАРГАСАН ШИНЖЭЭЧ:

Ж.БААТАР




Хууль зүйн ухааны доктор, хошууч генерал

Ч.БААТАР




Эдийн засгийн ухааны доктор, профессор, хурандаа

З.БОЛДБААТАР




Цэргийн ухааны доктор, профессор, хошууч генерал

П.БАЯРСАЙХАН



Аюулгүй байдал судлалын магистр, судлаач

О.БАТСАЙХАН




Түүхийн шинжлэх ухааны доктор

М.ГАНБОЛД




Хууль зүйн ухааны доктор, хошууч генерал

Ж.ЛХАГВАДЭМЧИГ




Антропологийн ухааны доктор

Л.МОЛОМЖАМЦ



Дэслэгч генерал, судлаач


Д.МЯГМАР



Шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал,

Геополитик судлалын хүрээлэнгийн захирал

О.ҮРЖИН



Цэргийн ухааны доктор, хошууч генерал




Д.ЧИМЭД-ЮНДЭН



Аюулгүй байдал судлалын ухааны доктор, хошууч генерал

Д.ЭНХБАТ



Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд

Д.ЭНХСАЙХАН



ҮАБЗ-ийн Ажлын албаны ахлах референт